

Жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэх тухай зөвлөмж

Өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийн гол эх сурвалж нь хувьцаа эзэмшигчдийн хурал болон жилийн үйл ажиллагааны тайлан, компанийн цахим хуудас гэж үздэг. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан /annual report/ нь санхүүгийн тайлангийн хамт компанийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн илэрхийлэхийн сацуу тус компанийн имиджийг бүрдүүлж, нэр хүндийг өсгөх өргөн боломжийг олгодог чухал хэрэгслийн нэг юм.

Олон улсын сайн туршлагаас үзэхэд жилийн тайлан нь дараах агуулгатай байдаг.

- Байгууллагын стратеги, түүнд хүрэх арга зам болон бизнес модел буюу хэрхэн урт хугацаанд компанийн үнэ цэнийг бий болгох, түүнийг хадгалах тухай,
- Зах зээлийн судалгаа шинжилгээ /макро эдийн засгийн болон салбарын чиг хандлага компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж буй бөгөөд ирээдүйд ямар нөлөөтэй тухай/
- Бизнесийн эрсдэл, ирээдүйн тодорхойгүй, эргэлзээтэй асуудлууд: гадаад, дотоод хүчин зүйлсийн эрсдлүүдийг тодорхойлж, түүнийг даван туулах/ боломж болгон ашиглах талаар авч хэрэгжүүлсэн болон цаашид авах арга хэмжээний тухай
- Үйл ажиллагааны гүйцэтгэл, санхүүгийн гол үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдтэй харьцуулан дүгнэсэн тайлбар, үйл ажиллагааны чиглэл бүрээр хийсэн шинжилгээ,
- Компанийн засаглалын бүтэц, ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, ажлын туршлага, гүйцэтгэх удирдлагад багтдаггүй гишүүдийн компанид үзүүлж буй хувь нэмэр, ТУЗ-ийн гишүүдийн шагнал, урамшууллыг компанийн санхүүгийн үр дүнтэй харьцуулан дүгнэсэн байдал, ТУЗ-аас зохион байгуулсан хувьцаа эзэмшигчидтэй холбоотой үйл явдлын хуанли
- Үнэт цаастай холбоотой мэдээлэл /ханшийн статистик, ногдол ашгийн бодлого г.м/
- Тогтвортой хөгжлийн бодлого /ажилчид, байгаль орчин, нийгмийн хариуцлага, бизнесийн гол түншүүдтэй холбоотой асуудлууд г.м/

Хуулийн шаардлага:

Компани жилийн үйл ажиллагааны тайланг 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх үүрэгтэй. Үүнд дор дурьдсан хууль журмыг удирдлага болгоно:

- Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйл
- Санхүүгийн Зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд хүргэх тухай журам”-ын 2 дугаар бүлэг.

Дэлгэрэнгүйг дараах хуудаснаас үзнэ үү.

ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН:

ТОВЧ АГУУЛГА:

1. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- БИЗНЕС МОДЕЛ, СТРАТЕГИ
- ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ
- ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2. ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн ур чадвар, ажлын туршлага, тэдгээрийн компанид үзүүлж буй хувь нэмэр
- БИЗНЕСИЙН ЭРСДЭЛ, ирээдүйн тодорхойгүй/эргэлзээтэй асуудлууд
- ТУЗ-ийн гишүүдийн шагнал, урамшууллыг компанийн санхүүгийн үр дүнтэй харьцуулан дүгнэсэн байдал
- КЗ-ын кодексийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй байдал

3. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

- Ханшийн статистик
- Үнэт цаас гаргасан түүх /хувьцаа хуваасан, нэмж гаргасан г.м/
- Ногдол ашгийн бодлого, мэдээ
- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

4. САНХҮҮГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН, ТОДРУУЛГУУД

- Санхүүгийн тайлангууд
- Нэмэлт тодруулга
- Хөндлөнгийн аудитын дүгнэлт

Дэлгэрэнгүйг дараах хуудаснаас үзнэ үү.

ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН:
ХУУЛЬ ЖУРМЫН ШААРДЛАГА БА ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

Хууль эрхзүйн шаардлага		Олон улсын сайн туршлага	
I. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА			
“Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай” журам /СЗХ-ны журам/	2.3.1	Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилт	¹ Бизнес модел & стратеги -Бизнес модел буюу хэрхэн компанийн үнэ цэнийг бий болгох, түүнийг хадгалах тухай -Компанийн стратеги, түүний амжилт үр дүнг илэрхийлж буй гол үзүүлэлтүүд
СЗХ-ны журам	2.3.2	Тухайн үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзэлж буй байр суурь	² Зах зээлийн судалгаа шинжилгээ -Макро эдийн засгийн болон салбарын чиг хандлага компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж буй бөгөөд ирээдүйд ямар нөлөөтэй тухай, авах арга хэмжээ -Компанийн бусдаас /өрсөлдөгчид/ ялгарах онцлог, зах зээлд эзлэх байр суурь ...
Компанийн тухай хууль /КТХ/	96.4	Тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, түүний үр дүн, ...	³ Үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн -Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг илэрхийлэх санхүүгийн болон санхүүгийн бус гол үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдтэй харьцуулан дүгнэсэн тайлбар - ^{3.1} Үйл ажиллагааны чиглэл (бүс нутаг, нэгж, бүтээгдэхүүн) тус бүрээр хийсэн шинжилгээ (зах зээлийн чиг хандлага, эрсдэл)
СЗХ-ны журам	2.5.2	... санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт;	

СЗХ-ны журам	2.5.8	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл:	Бизнесийн үйл ажиллагаанд гарсан томоохон өөрчлөлтүүд Компанийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлд гарсан өөрчлөлт Ж: нэгдэх нийлэх, эрх хүлээн авагч томилогдох, дампуурлын процесс г.м/, их хэмжээний хэлцэл хийгдсэн эсэх...
Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /ҮЦЗЗТХ/	56.1.3.	Үнэт цаас гаргагч болон түүний охин, хараат, зэргэлдээ компанид зохион байгуулалтын өөрчлөлт орсон;	
КТХ ҮЦЗЗТХ СЗХ-ны журам	96.4.1, 56.1.1, 2.3.9	...компанийн бүтэц зохион байгуулалт, үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;	
ҮЦЗЗТХ	56.1.4.	Үнэт цаас гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;	
ҮЦЗЗТХ	56.1.5.	Үнэт цаас гаргагч /ҮЦГ/ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;	
СЗХ-ны журам	2.5.9	Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний ... хэлцлийн мэдээлэл	Гүйцэтгэх удирдлагын тайлан /MD&A/ Компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн & санхүүгийн байдалд гарсан өөрчлөлтийн талаар дүгнэх: -Төлбөр гүйцэтгэх чадвар, -Хөрөнгийн эх үүсвэр, -Орлого зардал, ашиг алдагдлын өсөлт/бууралт... зэрэгт нөлөөлсөн & нөлөөлөх магадлалтай хүчин зүйлс -Балансаас гадуурх аливаа хэлцэл, үүргүүдийн тухай <i>Тайлбар:</i> дээрх 2 асуудлыг нэгтгэх боломжтой. Өөрөөр хэлбэл, MD&A нь онцгой үйл явдал, ердийн бус гэрээ хэлцэл, гүйлгээ зэргийг тайлбарлах, цаашид анхаарах асуудлыг дүгнэн хэлэлцэх зорилготой.
СЗХ-ны журам	2.5.10	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан	
СЗХ-ны журам	2.5.6	Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлтийн мэдээлэл	
СЗХ-ны журам	2.5.3	Тухайн жилийн санхүүгийн тайлангаарх ҮЦГ-ийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа	

II. ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

СЗХ-ны журам	2.3.4	-ҮЦГ-ийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд /КТХ 84/-ын талаарх мэдээлэл	<p>⁴Компанийн засаглалын бүтэц, ТУЗ-ийн тайлан</p> <p>-ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн ур чадвар, ажлын туршлага; тухайн жилд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт</p>
ҮЦЗЗТХ	56.2.6	-Удирдлага, зохион байгуулалтын бүтцэд орсон өөрчлөлт, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн талаарх мэдээлэл	
КТХ, СЗХ-ны журам	96.4.2, 2.5.1	-Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны эзэмшиж байгаа хувьцаа болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн хувь хэмжээ, тоо ширхэг;	
СЗХ-ны журам	2.5.7	-Бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл	
СЗХ-ны журам	2.3.8, /хавсралтын 6-р заалт/	-ҮЦГ-ийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл	
СЗХ-ны журам	2.5.11	ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан ...	
СЗХ-ны журам КТХ	2.3.6, 96.1.5*	Тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ	
СЗХ-ны журам	2.5.9	Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл, хэлэлцэж баталсан байдал	
СЗХ-ны журам	2.5.11	...Монголын КЗ-ын кодексийг хэрэгжүүлсэн талаарх тайлан, хэрэв кодексийн тодорхой заалтыг мөрдөөгүй бол түүний шалтгаан, тайлбар, мөрдөж эхлэх хугацаа	
СЗХ-ны журам	2.3.3	ҮЦГ-ийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл	
КТХ	81.4.1	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь ...ерсдлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавина.	
КЗ кодекс	Бүлэг 9	ТУЗ нь бүхий л эрсдлүүдийг тодорхойлж, эрсдлийн менежментээр хангах үйл ажиллагааг хариуцна.	

III. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ			
СЗХ-ны журам	2.5.4	Хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн мэдээ, ҮЦГ-ийн ногдол ашгийн бодлого	-Ханшийн статистик -Үнэт цаас гаргасан түүх /хувьцаа хуваасан, нэмж гаргасан г.м/ -Ногдол ашгийн бодлого, мэдээ
КТХ	46.15	ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг дараагийн ХЭХ-д заавал тайлагнана.	
СЗХ-ны журам	2.3.12	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл	-Хувьцаа эзэмшигчдийн бүтэц -ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчидтэй харилцсан байдал & Хувьцаа эзэмшигчидтэй холбоотой үйл явдал, мэдээллийн хуанли ҮЦ эзэмшигчдэд хүргэсэн мэдээлэл, түүнийг хүргэсэн хэлбэр -Мэдээллийн төрлүүд, тэдгээрийг авч болох хаягууд
СЗХ-ны журам	2.3.10	Хувьцаа эзэмшигчдийн хурал г.м	
БУСАД			
		Бусад мэдээлэл	⁶ Тогтвортой хөгжлийн бодлого -Ажилчид, байгаль орчин, нийгмийн хариуцлага г.м ³ Компанийн бизнесийн үйл ажиллагаанд чухал нөлөө бүхий бэлтгэн нийлүүлэгчид, бизнесийн гол түншүүдтэй холбоотой асуудлууд /гэрээ хэлцэл г.м/
IV. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД, НЭМЭЛТ ТОДРУУЛГА			
КТХ	96.1 /96.1.1- 96.1.4/	Санхүүгийн тайлан: баланс, орлого, мөнгөн гүйлгээ, хуримтлагдсан ашгийн тайлан	-Санхүүгийн тайлангууд -Нэмэлт тодруулгууд
СЗХ-ны журам	2.5.2	Аудитын байгууллагаар* баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга	-Хөндлөнгийн аудитын дүгнэлт
ҮЦЗЗТХ	20.1.6	*Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар ...	

Монгол улсын хууль эрх зүйн баримтуудад туссан “Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан”-тай холбоотой заалтуудыг түүвэрлэн нэгтгэж, олон улсын сайн туршилагатай

харьцуулах байдлаар боловсруулав. Олон улсын сайн туршилага хэсэгт АНУ-ын ҮЦХорооны 10-К тайлангийн маягт болон АНУ-ын “Хөрөнгө оруулагчдын нийгэмлэг” /IR society/ ТББ-аас гаргасан зөвлөмжийг удирдлага болгосон болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ НЭГЖ
cgovernance@mse.mn
